

МББСБХолбооны Удирдах Зөвлөлийн 2022 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн
ВМ..... дугаар шийдвэрийн .. дүгээр хавсралт



МОНГОЛЫН БАНК БУС САНХҮҮГИЙН
БАЙГУУЛЛАГУУДЫН ХОЛБООНЫ
ШАГНАЛЫН ЖУРАМ

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 1.1 Монголын Банк Бус Санхүүгийн Байгууллагын Холбоо /цаашид “Холбоо” гэнэ /-ны гишүүн байгууллагуудын үйл ажиллагааг дэмжих, тэдгээрийн зорилго, зорилтыг олон нийтэд таниулах, сурталчилах, Холбооны гишүүн шилдэг байгууллага, ажилтныг сонгон шалгаруулж, Холбооны болон бусад байгууллага, төрийн шагналд тодорхойлох, шагнаж урамшуулахтай холбогдон үүсэх харилцааг энэ журам /цаашид “Журам” гэнэ/-аар зохицуулна.
- 1.2 Санхүүгийн салбарын байгууллага, түүний ажилтны эрхэлсэн ажлын ололт амжилт, үр бүтээлийг гол шалгуур үзүүлэлт болгохын зэрэгцээ тухайн салбарт оруулсан бодит хувь нэмэр, эрхэлсэн ажилдаа онцгой амжилт гаргасан байдал, ач холбогдол бүхий үүрэг биелүүлсэн зэргийг харгалzan үзэх зарчмыг баримтална.
- 1.3 Холбооны гишүүн байгууллага, түүний ажилтан, албан хаагчийг шагналд тодорхойлох, сонгон шалгаруулах, шагнаж урамшуулах ажиллагааг Холбооны Удирдах Зөвлөлийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ.
- 1.4 Гишүүн байгууллага нь тухайн жилд Банк бус санхүүгийн байгууллагын шагналын 2-оос дээшгүй төрөлд нэрээ дэвшүүлж болох бөгөөд шаардлага хангасан 1 төрөлд шилдэгээр шалгарах боломжтой.
- 1.5 Холбооны тэгш ойн жилд ББСБ-уудын шилдэг ажилтнуудын шагнал болох “Банк бус санхүүгийн тэргүүний ажилтан”, “Хүндэт жуух” шагналыг Удирдах зөвлөлийн шийдвэрээр журмын 2.1.1, 2.1.2-т зааснаас нэмж олгож болно.

**ХОЁР. ХОЛБООНЫ ШАГНАЛ, ШАГНАЛЫН ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ,
ШАГНАЛД ТОДОРХОЙЛОХ**

- 2.1 Холбооны шагнал дараах төрөлтэй байх бөгөөд шагналд нэр дэвшигчдийг шалгуур үзүүлэлтээр дүгнэсэн онооны нийлбэр болон УЗ-ийн үнэлгээгээр үнэлж байр эзлүүлнэ.

ББСБ-уудын шилдэг ажилтнуудын шагнал:

- 2.1.1 Банк бус санхүүгийн тэргүүний ажилтан тэмдэг
 - Банк бус санхүүгийн салбарт 5-с доошгүй жил, тухайн байгууллагад 3-аас доошгүй жил тогтворт суурьшилтай, идэвхи зүтгэл, үр бүтээлтэй ажиллаж,

салбарын хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулж буй ажилтаныг “**Банк бус санхүүгийн тэргүүний ажилтан**” тэмдэгээр шагнаж болно.

- “Банк бус санхүүгийн тэргүүний ажилтан” тэмдэгээр нэг удаагийн арга хэмжээнд 10-с /арав/ дээшгүй тоогоор шагнан урамшуулна.
- Гишүүн байгууллагуудын түүхт 5, 10, 15, 20 ... жилийн ойн өдрийг тохиолдуулан 5-аас дээшгүй тоогоор шагнан урамшуулна.

2.1.2 Холбооны “Хүндэт жуух”

- Банк бус санхүүгийн салбарт 3-с доошгүй жил, тухайн байгууллагад 2-с доошгүй жил тогтвортой суурьшилтай, идэвхи зүтгэл, үр бүтээлтэй ажиллаж, салбарын хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулж буй ажилтаныг Холбооны “Хүндэт жуух”-ээр шагнан урамшуулна.
- Холбооны “Хүндэт жуух”-ыг нэг удаагийн арга хэмжээнд 10-с /арав/ дээшгүй тоогоор шагнан урамшуулна.
- Гишүүн байгууллагуудын түүхт 5, 10, 15, 20 ... жилийн ойн өдрийг тохиолдуулан 5-аас дээшгүй тоогоор шагнан урамшуулна.

2.1.3 Дээрх шагналуудыг дагалдах мөнгөн шагналын хэмжээг “Банк бус санхүүгийн тэргүүний ажилтан**” 300,0 мянган төгрөг, Холбооны “Хүндэт жуух” 150,0 мянган төгрөг хүртэлх хэмжээгээр тус тус тогтоож нэг удаа олгоно. Холбооны шагналын дагалдах мөнгөн шагналыг тухайн ажилтныг шагнуулахаар тодорхойлсон байгууллага нь өөрийн хөрөнгөөс гаргана.**

2.1.4 Оны шилдэг Салбарын захирал - 3 хүртэл ажилтан

- тухайн байгууллагад 2-с доошгүй жил ажилласан
- шинэ санал санаачлагыг нэвтрүүлсэн байдал
- манлайлсан байдал
- зөрчил дутагдалгүй
- тухайн байгууллагынхаа шилдэг ажилтан

2.1.5 Оны шилдэг Эдийн засагч-3 хүртэл ажилтан

- тухайн байгууллагад 2-с доошгүй жил ажилласан
- шинэ санал санаачлагыг нэвтрүүлсэн байдал
- манлайлсан байдал
- зөрчил дутагдалгүй
- тухайн байгууллагынхаа шилдэг ажилтан

2.1.6 Оны шилдэг Нягтлан бодогч-3 хүртэл ажилтан

- тухайн байгууллагад 2-с доошгүй жил ажилласан
- шинэ санал санаачлагыг нэвтрүүлсэн байдал
- манлайлсан байдал
- зөрчил дутагдалгүй
- тухайн байгууллагынхаа шилдэг ажилтан

2.1.7 Оны шилдэг ажилтан (харилцагчийн үйлчилгээний ажилтан, хүний нөөц, аудит, мэдээллийн технологийн ажилтан гэх мэт) - 3 хүртэл ажилтан

- тухайн байгууллагад 2-с доошгүй жил ажилласан
- шинэ санал санаачлагыг нэвтрүүлсэн байдал
- манлайлсан байдал
- зөрчил дутагдалгүй
- тухайн байгууллагынхаа шилдэг ажилтан

2.1.8 Журмын 2.1.4-2.1.7 заалт дах шагналууд Цом болон 100,0 мянган төгрөгийн шагналтай байна. Цомыг дагалдах мөнгөн шагналыг тухайн ажилтныг шагнуулахаар тодорхойлсон байгууллага нь өөрийн хөрөнгөөс гаргана.

Шилдэг байгууллагуудын шагнал:

2.1.11-2.1.13 шагналууд 5 тэрбум төгрөгөөс дээш активтай болон 5 тэрбум төгрөгөөс доош активтай ББСБ-үүд гэсэн 2 ангилалаар шалгаруулна.

2.1.9. Оны онцлох хүн /байгууллага – 1 байгууллага

- Банк бус санхүүгийн салбарын нийгэм, эдийн засгийн чадавхийг дээшлүүлэх, тухайн салбарыг хөгжүүлэхэд идэвхи санаачлага гарган, шинэ төсөл хэрэгжүүлсэн, олон улсын үнэлгээ хийлгэсэн, инноваци технологийн шинэ шийдэл нэвтрүүлсэн онцгой хувь нэмэр оруулсан хувь хүн, байгууллагыг “**Оны онцлох хүн /байгууллага**” өргөмжлөөр шагнан урамшуулна.

2.1.10. Оны шилдэг байгууллага - 1 байгууллага

- Гишүүнчлэлийн хугацаа 3-аас дээш жил болсон
- татвар, нийгмийн даатгалын өргүй-10 оноо
- нийгмийн хариуцлагаа хэрэгжүүлсэн байдал-ажлын байрны тооны өсөлт-10
- активын өсөлт-15
- зээлийн багцын чанар-15
- СЗХ-ны зохистой харьцааны шалгуурыг тухайн жилдээ хангаж зөрчилгүй ажилласан-20
- шинэ үйлчилгээ, техник технологийн дэвшлийг нэвтрүүлсэн байдал-10
- холбооны үйл ажиллагаанд идэвхтэй оролцож дэмжлэг үзүүлсэн байдал-20

2.1.11. Оны шилдэг санхүүгийн хүртээмжтэй байгууллага - 2 байгууллага

- Гишүүнчлэлийн хугацаа 2-оос дээш жил болсон
- Активын өсөлт-20
- Харилцагчийн тооны өсөлт-30
- Салбар нэгжийн тооны өсөлт-10
- Ажлын байрны тооны өсөлт-20
- Холбооны үйл ажиллагаанд идэвхтэй оролцож дэмжлэг үзүүлсэн байдал-20

2.1.12. Оны шилдэг бүтээгдэхүүн үйлчилгээтэй байгууллага - 2 байгууллага

- Гишүүнчлэлийн хугацаа 2-оос дээш жил болсон
- Зах зээлд шинээр нэвтрүүлсэн бүтээгдэхүүний үйлчилгээний нэр төрөл, анхдагч байдал-20
- Харилцагчдын эрэлт хэрэгцээнд нийцсэн байдал-20
- Өргөн хүрээг хамарсан байдал-20
- Шинэ техник технологи нэвтрүүлсэн байдал-20
- Холбооны үйл ажиллагаанд идэвхтэй оролцож дэмжлэг үзүүлсэн байдал-20

2.1.13. Оны шилдэг нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэгч байгууллага - 2 байгууллага

- Гишүүнчлэлийн хугацаа 2-оос дээш жил болсон
- Тухайн жилд нийгмийн сайн сайхны төлөө шинэ санал санаачилга дэвшүүлж, идэвх зүтгэл, хүчин чармайлт гарган, нийгмийн өмнө хүлээсэн хариуцлагаа ухамсартайгаар хэрэгжүүлсэн байх. /Хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарлуулсан

- зарын эх хувь, фото зураг, санхүүгийн баримт зэргээр хийгдсэн ажил үйлчилгээг баталгаажуулсан байх/-30
- Хэрэгжүүлсэн ажил нь өргөн хүрээг хамарсан байх-30
 - Татвар төлөлтийн байдал-10
 - Холбооны үйл ажиллагаанд идэвхи санаачлагатай ажилласан байх-30
- 2.1.14. Оны шилдэг Валют арилжааны байгууллага – 1 байгууллага
- Гишүүнчлэлийн хугацаа 2-оос дээш жил болсон
 - татвар төлөлт -10 оноо
 - гүйлгээний дүнгийн өсөлт - 30
 - харилцагчийн өсөлтийн байдал - 40
 - Холбооны үйл ажиллагаанд идэвхтэй оролцсон байдал – 20
- 2.2. Холбооны гишүүн байгууллага шагналд тодорхойлох байгууллага, ажилтны тухай дараах баримт бичгийг Холбооны Гүйцэтгэх захиралд хүргүүлнэ. Үнд:
- 2.2.1. Гишүүн байгууллагын тухайд гишүүн байгууллагын өөрийнх нь тодорхойлолт, гишүүн байгууллагын танилцуулга анкет, Байгууллагын талаарх харилцдаг татварын байгууллагын тодорхойлолт, СЗХ-ны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг сүүлийн 1 жилийн байдлаар хангасан тайлангийн хариу
- 2.2.2. Шагналд тодорхойлж байгаа байгууллагын тодорхойлолтод тухайн байгууллагын тухайн жилийн үйл ажиллагааны голлох санхүүгийн үзүүлэлтүүд (санхүүгийн тайлан хавсаргах), үйл ажиллагаанд нэвтрүүлсэн хөрөнгө оруулалт, ажил үйлчилгээний тухай тоон баримтууд, шинээр бий болгосон ажлын байрны тоо, хүрсэн үр дүнг тусгасан байна;
- 2.2.3. Ажилтан, албан хаагчийн тухайд ажилтны талаарх байгууллагын тодорхойлолт, хүсэлт, ажилтны анкет, ажилтны нийгмийн даатгалын лавлагааг ирүүлнэ;
- 2.2.4. Шагналд тодорхойлж байгаа ажилтны ажил байдлын тодорхойлолтод тухайн ажилтны сүүлийн 2-5 жилийн ажлын ололт амжилт, үр бүтээл, ажлын гол үзүүлэлт, хүрсэн үр дүнг тусгасан байна.
- 2.3. Тухайн жилд шалгуурыг хангах материалууд ирээгүй тохиолдолд аль нэг шагналыг олгохгүй байж болно.
- 2.4. Шагналын тодорхойлолтод байгууллагын Гүйцэтгэх захирал гарын үсэг зурж, тамга дарж баталгаажуулсан байна.
- 2.5. Үндэсний их баяр наадам, санхүү, эдийн засгийн ажилтны өдөр, тухайн салбарын, байгууллагын түүхт 5, 10, 15, 20 ... жилийн ойн өдрийг тохиолдуулан ойн өдөр, баяр болохоос 30-аас доошгүй хоногийн өмнө шагналын тодорхойлолтыг хүлээн авна.
- 2.6. Журмын 2.2 дугаар зүйлд заасан баримт бичгийг бүрэн бүрдүүлээгүй тохиолдолд шагналын тодорхойлолтыг хүчингүйд тооцно.
- 2.7. Холбооны шагналд тодорхойлох /энэ журмын 2.1, 2.2 дугаар зүйлд заасан/ ерөнхий нөхцлийг хангаагүй, эсвэл тухайн байгууллага, ажилтны шагналын тодорхойлолт, түүнд холбогдох баримт бичгийг хугацаанаас хожимдуулж ирүүлсэн тохиолдолд шагналын тодорхойлолтыг хүчингүйд тооцно.
- 2.8. Холбоо нь гишүүн байгууллага, түүний ажилтныг холбогдох төрийн болон салбарын төр захиргааны байгууллагуудын шагналд нэр дэвшүүлж болох бөгөөд шагналд нэр дэвшигчийг дэмжиж ажиллана.